



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР
2021

Улаанбаатар хот

2022 он

ТАНИЛЦУУЛГЫГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Б.Энхжаргал БЗД-ийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Т.Хаш-Эрдэнэ БЗД-ийн Статистикийн дарга

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС:

Монгол Улс, Улаанбаатар хот

Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-57

Төр захиргааны II байр

Утас: (976-51)-267349, 261728, 261019

Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn, <http://ubstat.mn>

И-мэйл: Bayanzurkh@nso.mn

МАЛ ТООЛЛОГЫН ДҮНГЭЭР ХИЙСЭН СУДАЛГАА-2021
АГУУЛГА

Хуудас

Оршил	1
Нэг. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	2
Хоёр. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ	4
Гурав. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ	6
Дөрөв. ТЭЖЭЭВЭР АМЬТАД	11
Тав. ГАЗАР ТАРИАЛАН	12
Зургаа. ДҮГНЭЛТ	14

ОРШИЛ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг билээ. Иймээс монгол улсын үндсэн хуульд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогын ажлыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газрын удирдамж зааврын дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсүүд жил бүрийн 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг зохион байгуулж явуулдаг билээ.

Үүний дагуу дүүрэгт 2021 оны мал тооллогыг нийслэлийн Засаг даргын А/928 тоот захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2021 оны 12 дүгээр сарын 03-ны өдрийн А/640 тоот захирамжаар энэ оны мал, тэжээвэр амьтдын тооллого явуулах ажлын хэсэг байгуулж, ажиллах удирдамжийг батлуулан тооллогын хугацаанд амжилттай зохион байгуулж явууллаа.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь дүүргийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулахад суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Нэг. ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Таван хошуу малыг бодод шилжүүлэх коэффициент:

- 1 адуу – 1 бод
- 1 үхэр – 1 бод
- 6 хонь – 1 бод
- 8 ямаа – 1 бод

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент:

- 1 тэмээ – 5 хонь
- 1 адуу – 7 хонь
- 1 үхэр – 6 хонь
- 1 ямаа – 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

- Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
- Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
- Бог мал /хонь, ямаа/ - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

- Адуу – Өнгөрсөн жилийн төл, 2 настай
- Үхэр – Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт болон худалдаж авсан, шилжиж ирсэн мал, зарлага тал нь худалдсан, шилжүүлсэн мал болон хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 10-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

- 1 Азарга – 10 гүү
- 1 Бух – 25 үнээ
- 1 Хуц, ухна – 50-60 эм хонь, эм ямаа

Том малын зүй бусын хорогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан гэх мэт) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны хангамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

- | | |
|-------------------------|--|
| ➤ Хадлан өвс | 0.45 |
| ➤ Таримал тэжээл | 0.35 |
| ➤ Даршны ургамал | 0.25 |
| ➤ Гар тэжээл, хужир шүү | 1.0 |
| ➤ Үр тарианы хаягдал | 0.9 |
| ➤ Лай | 0.4 |
| ➤ Сүрэл | 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ. |

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна. Үүнд:

- Бүдүүн тэжээл – Өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс
- Хүчит тэжээл – Үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
- Шүүст тэжээл – бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал

Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно. Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Хоёр. МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДГЭЭРИЙН СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МАЛ БҮХИЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО

2021 оны мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд 1005 өрх, 6 аж ахуйн нэгж байгууллага тоологдсон байна. Үүний 783 (77.9%) өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 222 (22.1%) өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөж үржүүлж буй малтай өрх байна.

Хүснэгт 1. Малчин, малтай өрхийн тоо 2016-2021 он


Үзүүлэлт	Хороо	2016	2017	2018	2019	2020	2021
Малтай өрх	2-р хороо	2	1	-	-	-	-
	8-р хороо	3	3	-	-	-	-
	9-р хороо	42	27	-	-	-	-
	10-р хороо	3	3	-	-	-	-
	11-р хороо	243	224	223	179	204	201
	12-р хороо	-	-	-	-	-	-
	16-р хороо	-	-	-	-	-	-
	17-р хороо	-	-	-	-	-	-
	19-р хороо	-	-	-	-	-	-
	20-р хороо	703	722	761	788	840	804
	21-р хороо	6	3	-	-	-	-
	22-р хороо	-	-	-	-	-	-
	23-р хороо	20	19	-	-	-	-
	24-р хороо	2	1	-	-	-	-
	27-р хороо	1	-	-	-	-	-
	28-р хороо	9	7	-	-	-	-
Дүүргийн дүн		1 022	1 034	984	967	1 044	1 005
Малчин өрх	9-р хороо	18	10	-	-	-	-
	10-р хороо	1	-	-	-	-	-
	11-р хороо	75	26	87	89	109	120
	20-р хороо	220	275	245	549	633	663
	21-р хороо	2	2	-	-	-	-
	23-р хороо	-	-	-	-	-	-
	24-р хороо	1	1	-	-	-	-
	28-р хороо	1	-	-	-	-	-
Дүүргийн дүн		247	318	332	638	742	783

2021 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 783 малчин мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шимийг амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 12.0 хувь нь 15-34 насны, 59.2 хувь нь 35-59 насны, 28.8 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна. Нийт малчдын 68.1 хувь нь эрэгтэй 31.9 хувь нь эмэгтэй байна.

Хүснэгт 2.Малтай болон малчин өрх, малчдын тоо 2016-2021 он

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
Малтай өрх	1 034	1 010	984	967	1 044	1 005
Түүний ам бүл	3 106	2 794	2 537	2 230	2 651	2 879
Малчин өрх	318	314	332	638	742	783
Түүний ам бүл	1 055	922	878		1 951	2 213
Малчдын тоо	599	402	415	761	835	989
Үүнээс: 16-34 насны	60	69	51	90	103	119
35-59 насны	490	283	237	492	463	585
60 ба түүнээс дээш	49	50	217	179	269	285
Эмэгтэй	289	122	99	237	212	315
Насны бүтэц %	100	100	100	100	100	100
Үүнээс: 16-34 насны	10.0	17.2	12.3	11.8	12.3	12.0
35-59 насны	81.8	70.4	57.1	64.7	55.5	59.2
60 ба түүнээс дээш	8.2	12.4	30.6	23.5	32.2	28.8

Зураг 1.Малтай болон малчин өрх, малчдын тоо 2016-2021 он



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт: 2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт малчин өрхийн 72.3 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 58.2 хувь нь сансарын антентай, 63.4 хувь нь телевизортой, 13.1 хувь нь радиотай байна. 29.8 хувь нь оёдлын машинтай, 48.9 хувь нь хөлдөөгчтэй, 44.3 хувь нь угаалгын машинтай байна.

Хүснэгт 3. Малчин өрхийн соёл, ахуйн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2016	2017	2018	2019	2020	2021
	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
Цахилгаан эх үүсгүүртэй	229	291	263	616	671	715	72	92.6	79.2	80.9	80.3	72.3
Телевизортой	18	92	249	598	659	627	5.6	29.3	75	78.6	78.9	63.4
Сансарын антенн	17	89	231	588	655	576	5.3	28.3	96.5	77.3	78.4	58.2
Радио	1	41	43	93	20	130	0.3	13	12.9	12.2	2.4	13.1

Гурав . МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо: 2021 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын дүнгээр дүүргийн хэмжээнд 2 хороонд 1 005 өрхийн 59 425 толгойд хүрч өнгөрсөн оныхоос 379 (0.6%) толгой малаар буурсан байна.


Хүснэгт 4. Малын тоо, төрлөөр 2016-2021 он

Малын төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	2021/2020	
							Зөрүү	Хувь
Тэмээ	2	-	-	-	-	-	-	-
Адуу	5 515	5 882	5 473	6 408	7 482	8 862	1 380	18.4
Үхэр	18 464	17 824	16 460	17 795	18 918	17 097	1 821	-9.6
Хонь	17 401	17 415	16 102	17 644	17 171	18 200	1 029	6.0
Ямаа	13 937	13 847	13 092	15 086	16 233	15 266	967	-5.9
Бүгд	55 319	54 968	51 127	56 933	59 804	59 425	379	-0.3

Энэ жилийн тооллогоор адуу 1380 (18.4%), хонь 1029 (6.0%) тус тус өссөн бол үхэр 1821 (9.6%), ямаа 967 (5.9%) буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2021 оны мал тооллогоор нийт 443320 толгой мал тоологдсоны 13.4 хувийг Баянзүрх дүүрэг эзэлж байна.

Зураг 2. Дүүргийн малын тоо, мянган толгой, 2017-2021 он



Хүснэгт 5. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бүгд	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	-	0.004	0.004	-	-	-	-	-
Адуу	9.3	7.7	10.0	10.7	10.7	11.3	12.5	14.9
Үхэр	33.8	37.0	33.4	32.4	32.2	31.3	31.6	28.8
Хонь	29.4	29.0	31.5	31.7	31.5	31	28.7	30.6
Ямаа	27.5	26.3	25.2	25.2	25.6	26.4	27.2	25.7


2021 оны байдлаар нийт мал сүргийн 43.7 хувийг бод мал, 56.3 хувийг бог мал эзэлж байна. Нийт сүрэгт адуу 14.9 хувь, үхэр 28.8 хувь, хонь 30.6 хувь, ямаа 25.7 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Малын орлого, зарлага, төрлөөр, 2021 он

Төрөл	Оны эхэнд	Орлого		Зарлага						Оны эцэст
		Худалдаж авсан, шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	шилжүүлсэн	Алдсан	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол	Бусад	
Тэмээ	-	-	-	-	-	-	-	-	-	-
Адуу	7 482	2 066	1 425	533	27	1 134	201	216	-	8 862
Үхэр	18 918	2 268	4 691	566	53	5 903	1 508	750	-	17 097
Хонь	17 171	3 138	5 729	560	7	5 558	1 106	607	-	18 200
Ямаа	16 233	3 003	3 854	643	2	5 512	989	678	-	15 266
Дүн	59 804	10 475	15 699	2 302	89	18 107	3 804	2 251	-	59 425

2021 онд бэлэн тоологдсон төл 15699 толгойгоор, худалдаж авсан, шилжиж ирсэн мал 10475 толгойгоор тус тус орлого талыг нэмэгдүүлж байхад харин бусдад худалдсан болон шилжүүлсэн малын тоо 2302 толгой, зах зээлд борлуулсан малын тоо 18107 толгой, хүнсэнд хэрэглэсэн малын тоо 3804 толгой, зүй бус хорогдол 2251 толгой, алдсан малын тоо 89 толгой болж зарлага талын гол үзүүлэлтийг тодорхойлж байна.

Зураг 3. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь, 2018-2021 он



Малын тоо хороогоор: Малын тоог хороо тус бүрээр нь харахад 2021 оны мал, тэжээвэр амьтадын тооллогоор дүүргийн нийт малын 82-оос дээш хувийг эзэлдэг 20 дугаар хороо нь 48734 толгой мал тоолуулсан ба 2020 оноос 878 (1.8%) толгой малаар малын тоо толгой бүүрсан бол 18 хувийг эзэлж байгаа 11 дүгээр хороо нь 10691 толгой мал тоолуулсан нь 2020 оноос 499 толгой малаар буюу 4.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 7.Малын тоо, ААНБ, Тавиул малтай өрх

Хороо	Адуу		Үхэр		Хонь		Ямаа		Бүгд	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Бүгд	7 482	8 862	18 918	17 097	17 171	18 200	16 233	15 266	59 804	59 425
Үүнээс:										
ААНБ	23	27	34	33	115	194	127	236	299	490
Тавиул малтай өрх	108	-	42	-	-	-	-	-	150	-

Хүснэгт 8.Малын тоо, хороогоор, 2020-2021 он

Хороо	Адуу		Үхэр		Хонь		Ямаа		Бүгд	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Бүгд	7 482	8 862	18 918	17 097	17 171	18 200	16 233	15 266	59 804	59 425
11 хороо	2 258	2 397	2 823	2 555	2 872	3 480	2 239	2 259	10 192	10 691
20 хороо	5 224	6 465	16 095	14 542	14 299	14 720	13 994	13 007	49 612	48 734

2021 оны мал тооллогоор амины малын тоо 58935 толгой болж нийт малын 99.2 хувийг эзэлж байна. Аж ахуйн нэгжийн малын тоо 490 толгой буюу 0.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 9.Хувийн малтай өрх, малын тоо, 2013-2021 он

Он	Малтай өрх	Бүгд	Үүнээс:					1 өрхийн дундаж мал
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2013	960	42 640	-	2 819	13 463	14 015	12 677	44
2014	933	46 054	-	4 271	15 583	13 505	12 695	50
2015	1 017	49 979	2	3 851	18 489	14 470	13 167	49
2016	1 025	55 176	2	5 510	18 410	17 317	13 937	54
2017	1 010	54 859	-	5 877	17 777	17 358	13 847	54
2018	984	50 867	-	5 383	16 366	16 027	13 091	51
2019	967	56 933	-	6 386	16 433	14 711	15 033	59
2020	1 044	59 804	-	7 482	18 918	17 171	16 233	57
2021	1 005	59 425	-	8 862	17 097	18 200	15 266	59

2021 оны байдлаар 1 өрх дунджаар 59 толгой малтай болсон нь өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 2 толгой малаар нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Малтай өрхийн малын бүлэглэлт, 2019-2021 он

Малын бүлэглэлт	Өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021
Бүгд	967	1 044	1 005	100	100	100	56 766	59 505	59 425
10 хүртэл малтай	271	311	302	28	29.8	30.0	1 509	1 721	1 777
11-30 малтай	324	342	329	33.5	32.8	32.8	5 964	6 340	6 208
31-50 малтай	123	129	128	13	12.4	12.7	4 706	4 888	5 037
51-100 малтай	115	119	113	11.9	11.4	11.2	7 909	8 386	8 204
101-200 малтай	57	69	69	6.6	6.6	6.9	7 827	9 490	9 211
201-500 малтай	64	59	48	6.6	5.6	4.8	19 802	18 366	16 491
501-999 малтай	12	14	11	1.2	1.3	1.1	7 785	9 306	6 297
1000-1499 малтай	1	1	5	0.1	0.1	0.5	1 264	1 008	5 710
1500-2000 малтай	-	-	-	-	-	-	-	-	-

2021 оны мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогоны дүнгээс малын бүлэглэлт тус бүрээр авч үзэхэд 10 хүртэлх толгой малтай 1 өрхөд 5-6 толгой мал, 11-30 малтай 1 өрхөд 18-19 толгой мал, 31-50 малтай 1 өрхөд 39-40 толгой мал, 51-100 малтай 1 өрхөд 72-73 толгой мал, 101-200 малтай 1 өрхөд 133-134 толгой мал, 201-500 малтай 1 өрхөд 343-344 орчим толгой мал, 501-999 малтай 1 өрхөд 572 орчим толгой мал, харин 1000-1499 малтай өрхийн бүлэгт манай дүүрэгт энэ жилийн хувьд 1 өрх тоологдсон ба 1142 толгой мал.

Хээлтэгч мал: 2021 оны эцэст 29733 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 644 (2.2%) толгойгоор өссөний дотор гүү 763 толгой, эм хонь 389 толгой, эм ямаа 36 толгой малаар өссөн бол үнээ 544 толгой малаар тус тус буурсан байна.

Хүснэгт 11. Хээлтэгч малын тоо, төрлөөр, 2015-2021 он

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021/2020	
								Зөрүү	Хувь
Бүгд	24 114	27 190	27 548	26 610	27 607	29 089	29 733	644	2.2
Гүү	1 252	1 827	2 218	2 039	2 287	2 627	3 390	763	29.0
Үнээ	8 660	8 901	8 850	8 719	8 727	8 994	8 450	544	-6.0
Эм хонь	7 557	9 251	9 087	8 519	9 082	9 077	9 466	389	4.1
Эм ямаа	6 645	7 211	7 393	7 333	7 511	8 391	8 427	36	0.4

Хүснэгт 12.Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд, 2015-2021 он

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021/2020	
								Зөрүү	Өсөлтийн хурд
Бэлэн тоологдсон төл	15 732	15 666	14 982	13 032	17 690	16 535	15 699	836	-5.0
Том малын зүй бус хорогдол	377	1678	1 066	1916	669	1 790	2 251	461	25.7
Хээлтэгч малын тоо	24 114	27 190	27 548	25 650	27 607	29 089	29 733	644	2.2
Хээл хаясан хээлтэгч	311	122	1 175	562	543	811	1 886	1 075	132.5
Сувайрсан хээлтэгч	3 850	5 423	3 584	1 438	2 053	3 514	4 933	1 419	40.4

2021 оны мал тооллогын дүнгээс харахад Хээлтэгч малын тоо 644 (2.2%) толгой мал, сувиарсан хээлтэгч 1419 (40.4%) толгой малаар өсөж, Хээл хаясан хээлтэгч мал 1075 (132.5%) толгой мал, Том малын зүй бус хорогдол 461 (25.7%) толгой малаар өссөн бол бэлэн тоологдсон төл 836 (5.0%) толгой мал буурсан байна.

Хүснэгт 13.Бойжуулсан төл, 2015-2021 он

Малын төрөл	2015	2016	2017	2018	2020	2021	2021/2020	
							Зөрүү	Өсөлтийн хурд
Бүгд	15666	14982	13 032	21 825	21 013	15 699	5 314	-25.3
Ботго	-	-	-	-	-	-	-	-
Унага	974	925	734	1 534	1 457	1 425	32	-2.2
Тугал	5 376	4 923	4298	5 812	6 827	4 691	2 136	-31.3
Хурга	5 440	5 485	4828	7 700	6 931	5 729	1 202	-17.3
Ишиг	3 876	3 649	3172	6 779	5 798	3 854	1 944	-33.5

2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор бойжуулсан төлийн тоо 15699 толгой болж өнгөрсөн оныхоос 5314 (25.3%) толгойгоор буурсан байна.

Хүснэгт 14.Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр, 2021 он

Малын төрөл	Төлөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан, шилжиж ирсэн	Худалдсан, шилжүүлсэн
Бүгд	20 096	20 097	1 508	18 589	741	3 631
Унага	1 882	1 882	109	1 773	38	386
Тугал	5 674	5 674	375	5 299	187	795
Хурга	6 226	6 226	301	5 925	460	656
Ишиг	6 314	6 315	723	5 592	56	1794

Том малын зүй бус хорогдол: 2021 оны тооллогоор 2251 том мал хорогдсон бөгөөд өнгөрсөн оныхоос 461 (25.7%) толгойгоор өссөн байна. Нийт хорогдсон малын 9.6 хувийг адуун сүрэг, 33.3 хувийг үхэр сүрэг, 27.0 хувийг хонин сүрэг, 30.1 хувийг ямаан сүрэг тус тус эзэлж байна.

Хүснэт 15.Том малын зүй бус хорогдол, 2015-2021

Малын төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021/2020	
								Зөрүү	Өсөлтийн хурд
Бүгд	377	1 678	1 066	1 916	669	1 790	2 251	461	125.7
Адуу	51	79	206	185	132	370	216	154	-41.6
Үхэр	151	623	295	850	196	322	750	428	132.9
Хонь	77	547	297	429	210	503	607	104	20.7
Ямаа	98	429	268	452	131	595	678	83	13.9

2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт хорогдсон малын 24 (1.1%) толгой мал нь өвчнөөр хорогдсон байна.

Дөрөв. ТЭЖЭЭВЭР АМЬТАД

2021 онд дүүргийн нийт 5692 гэрийн тэжээвэр амьтад тоологдсон бөгөөд дийлэнх нь буюу 94.9 хувийг шувуу эзэлж байна.

Хүснэгт 16.Тэжээвэр амьтад, төрлөөр, 2014-2021 он

Тэжээвэр амьтдын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021/2020
									Зөрүү
Нийт	1 102	759	652	982	6 650	5 608	5 548	5 692	144
Гахай	711	370	202	237	147	125	180	197	17
Шувуу	329	332	412	687	6 450	5 428	5 308	5 403	95
Цаа	-	-	-	-	-	-	-	2	2
Илжиг	-	1	-	2	-	-	-	3	3
Туулай	30	10	7	11	14	11	16	27	11
Минж	-	-	31	45	39	44	44	48	4
Зөгийн бүл	10	46	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	-	12	12

2021 онд дүүргийн нийт 28 хороонд гэрийн тэжээвэр 11451 нохой, 349 муур байна. Тэжээвэр муур, нохойны бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохой 521 буюу 4.8 хувиар муур 35 буюу 11.1 хувиар буурчээ.

Хүснэгт 17.Тэжээвэр амьтдын тоо, хороогоор, 2021 он

Хороо	Нохой		Зөрүү	Муур		Зөрүү
	2020	2021		2020	2021	
Нийт	10 930	11 451	-521	314	349	-35
1-р хороо	49	38	11	19	19	-
2-р хороо	244	228	16	7	9	-2
3-р хороо	35	7	28	1	3	-2
4-р хороо	250	271	-21	16	21	-5
5-р хороо	578	688	-110	10	38	-28
6-р хороо	7	12	-5	2	7	-5
7-р хороо	22	17	5	1	1	-
8-р хороо	386	348	38	11	9	2
9-р хороо	1 429	1 331	98	-	10	-10
10-р хороо	328	211	117	12	2	10
11-р хороо	494	507	-13	16	16	-
12-р хороо	568	598	-30	27	21	6
13-р хороо	165	164	1	2	2	-
14-р хороо	59	150	-91	7	7	-
15-р хороо	12	11	1	7	10	-3
16-р хороо	27	34	-7	3	15	-12
17-р хороо	937	1 023	-86	16	15	1
18-р хороо	37	38	-1	7	8	-1
19-р хороо	727	766	-39	1	3	-2
20-р хороо	394	421	-27	19	19	-
21-р хороо	470	821	-351	5	20	-15
22-р хороо	380	412	-32	12	12	-
23-р хороо	1 628	1 704	-76	-	-	-
24-р хороо	395	380	15	-	-	-
25-р хороо	42	39	3	11	14	-3
26-р хороо	31	36	-5	4	4	-
27-р хороо	697	686	11	75	50	25
28-р хороо	539	510	29	23	14	9

Тав. ГАЗАР ТАРИАЛАН

Газар тариалан: Баянзүрх дүүргийн хэмжээнд 2021 онд 3.144 га талбайд төмс тариалж, 65.509 тонн ургац хураан авсан бол, 7.5267 га талбайд хүнсний ногоо тариалж, 57.154 тонн ургац хураан авсан байна. Мөн 6149.0 тонн өвс өөрсдөө болон худалдан авч бэлтгэсэн байна.

Хүснэгт 18. Ургац хураалт, хадлан тэжээлийн мэдээ, тонн

Нэр, төрөл	Хураасан талбай /га/		Хураасан ургац, бүгд /тн/		Хүлэмжээс	
	2020 XI	2021 XI	2020 XI	2021 XI	2020 XI	2021 XI
Төмс	7.1487	2.6353	82.227	65.509	-	-
Хүнсний ногоо	2.34055	6.9206	55.433	57.154	29.5685	33.562
Байцаа	0.28345	0.0936	5.116	4.029	0.168	0.13
Лууван	0.2738	0.2688	5.666	5.793	0	0.12
Шар манжин	0.097	1.0458	3.205	3.597	0.1	0.05
Улаан манжин	0.0358	0.0384	1.348	2.197	0	0.05
Сонгино	0.1656	0.1353	6.212	5.063	0.79	2.406
Сармис	0.0482	0.0338	1.684	0.489	0.296	0.24
Өргөст хэмх	0.4244	2.4892	13.533	12.489	11.3301	11.062
Улаан лооль	0.2659	1.5166	6.143	4.404	6.0926	3.579
Тарвас	0.0112	0.0002	0.307	0.06	0.303	-
Амтат гуа	0.0116	0.0036	0.312	0.167	0.306	0.147
Хулуу	0.04155	0.1186	1.828	1.816	1.215	1.101
Чинжүү	0.0356	0.0877	1.493	1.535	1.458	1.496
Бусад	0.65805	1.089	8.586	15.515	7.5098	13.181
Тэжээлийн ургамал	12.5002	13.006	49.1	27.2	-	-
Ногоон тэжээл	12.5	13	49	27	-	-
Даршны ургамал	0.0002	0.006	0.1	0.2	-	-
Эрдэнэшиш	0.0002	0.006	0.1	0.2	-	-
Техникийн ургамал	0.0004	-	0.0005	-	-	-
Чихрийн манжин	-	-	-	-	-	-
Рапс	-	-	-	-	-	-
Наранцэцэг	0.0004	-	0.0005	-	-	-
Бэлтгэсэн өвс	-	-	3537.57	6 149.0	-	-
Өөрсдийн бэлтгэсэн	-	-	2446.5	4 950.8	-	-
Худалдаж авсан	-	-	1091.07	1 198.2	-	-

Хүснэгт 19. Ургац хураалт, хадлан тэжээлийн мэдээ, тонн

Хороо	Хураасан ургац, бүгд /тонн/				
	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Техникийн ургамал	Бэлтгэсэн өвс
2-р хороо	0.3	0.65			
5-р хороо	0.884	2.79			
9-р хороо	3.86	7.658			
10-р хороо	-	1.279			
11-р хороо	55.835	19.587			899.7
12-р хороо	3.55	9.405	0.2		
17-р хороо	0.558	0.3			
20-р хороо		9.31	27		5 249.3
21-р хороо	0.025	1.721			
23-р хороо	0.25	0.678			
28-р хороо	0.257	3.776			

ДҮГНЭЛТ

2014 оноос хойшхи мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээс харахад дүүргийн малын тоо өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ын дүнгээр 59425 толгой мал тоолуулж 379 толгой мал буюу -0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд мал бүхий 2 хорооны 6 аж ахуйн нэгж байгууллага, 1005 өрхийн 59425 толгой мал тоологдсныг төрөл тус бүрээр авч үзвэл:

- Адуу – 8862
- Үхэр – 17097
- Хонь – 18200
- Ямаа – 15266 толгой малтай байна.

Бог малын бүтцэд 2021 оны байдлаар бог малын 30.6 хувийг хонин сүрэг, 25.7 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор амины малын тоо 58935 толгой болж нийт малын 99.2 хувийг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд тэжээвэр амьтан бүхий 28 хорооны өрх, аж ахуйн нэгж байгууллагын нийт гахай 197, шувуу 5403, туулай 27, минж 48, нохой 11451, муур 349 тус тус тоологдсон болно.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС: